



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№239 /448/

2022.01.04

Цаг үе, үйл явдал

“ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХАТАН ИЖИЙ” НАР ХЦАХ-ДЫНХАА БАЯРТ МӨЧИЙГ ХУВААЛЦЛАА



Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулга ЗХЖШ-тай хамтран зохион байгуулдаг “Зэвсэгт хүчний Хатан ижий” ёслол хүндэтгэлийн арга хэмжээ цар хүрээгээ тэлсээр өдгөө 60 гаруй ээжүүдийг тодруулан алдаршуулаад байгаа билээ.

“Зэвсэгт хүчний Хатан ижий” ТББ ЦДБЭЧ-тай хамтран нийгэмд чиглэсэн, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын бие бүрэлдэхүүн, хугацаат цэргийн алба хаагчдад зориулсан олон арга хэмжээг санаачлан хэрэгжүүлсээр байна.

Тухайлбал ЦДБЭЧ, “Эр цэргийн Хатан ижий” ТББ хамтран хурандаа Ж.Мөнхбаяр захирагчтай Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн хугацаат цэргийн алба хаагчдаас 12 дугаар сард төрсөн өдөр нь тохиосон 16 алба хаагчийг баярлуулах арга хэмжээг зохион байгуулж нэгэн өдрийг баяр, талархал дүүрэн өнгөрүүлжээ.

Зэвсэгт хүчиндээ гэр бүлээрээ хөдөлмөр зүтгэлээ зориулж өдгөө үр хүүхдүүд нь тэдний үйлс бүтээлийг үргэлжлүүлэн төрийн цэргийн байгууллагад ажиллаж буй ижий нарын сэтгэлийн бэлгээр өнгө нэмсэн, ЦДБЭЧ-ын уран бүтээлчдийн аялгуу дуугаар сэтгэлээ хөглөсөн, дайчин эрсийн төрсөн өдрийн баяр, талархал, урам зориг дүүрэн болж өндөрлөсөн байна.


“ЦЭРЭГ-ЭХ ОРОНЧ ХҮМҮҮЖИЛ ОЛГОХ ТАНХИМ”-ЫГ 7 ДАХЬ СУРГУУЛЬДАА БАЙГУУЛЛАА

Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас хүүхэд, өсвөр үеийнхэнд эх орон, тусгаар тогтнолоо хайрлан хамгаалах, цэрэг эх-оронч хүмүүжил, төлөвшил олгох зорилгоор ЕБС-иудтай хамтран “Цэрэг эх-оронч хүмүүжил олгох танхим”-ыг шинээр байгуулсаар байна.

Уг ажлын хүрээнд Арвайхээр сумын ЕБ-ын тав, Хайрхандулаан сумын нэг сургуулийг тус тус тохижуулан хүлээлгэн өгөөд байсан бол энэ онд нэмэлтээр Хархорин сумын ЕБ-ын хоёрдугаар сургуулийн түүх-нийгмийн ухааны хичээлийн танхимыг “Цэрэг эх-оронч хүмүүжил олгох танхим” болгож тохижууллаа.

Тус танхимыг 1911, 1921, 1939, 1945, 1948 онуудад эх орныхоо тусгаар тогтнолын төлөө эрэлхгээр тулалдаж, халуун амь, бүлээн цусаа өргөсөн баатарлаг үйлстнүүдийг таниулан сурталчлах болон Монголын орчин цагийн Зэвсэгт хүчний талаар мэдлэг, ойлголт өгөх байдлаар тохижуулсан бөгөөд үүнд шаардагдах 3.7 сая төгрөгийг Цэргийн дүйцүүлэх албан хаагчдын орон нутгийн бүтээн байгуулалтад оролцсон ажлын хөрснөөс зарцуулав.

Өвөрхангай аймаг ЗДТГ-ын Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер дэд хурандаа Ч.АДЪЯА



ЦЭРГИЙН БҮРТГЭЛИЙГ НЭГДҮГЭЭР САРЫН 4-ӨӨС ЭХЛЭН E-MONGOLIA СИСТЕМЭЭР БҮРТГЭНЭ

ЦЭРГИЙН БҮРТГЭЛ ОРОН ДАЯАР

Онлайн үйлчилгээ

2023/01/04



Монгол Улсын иргэн 18-50 насны цэргийн үүрэгтнүүд, 65 хүртэлх насны бэлтгэл офицерууд, цэргийн бүртгэлтэй мэргэжил эзэмшсэн эмэгтэйчүүд жилд нэг удаа бүртгэлд хамрагдах үүрэгтэй байдаг.

Тэгвэл 2023 оны цэргийн бүртгэлийг нэгдүгээр сарын 4-30-ны өдрүүдэд орон даяар гурван сувгаар хийх юм. Тухайлбал, иргэд www.e-mongolia.mn сайт, E-Mongolia гар утасны аппликэйшн болон төрийн үйлчилгээний оператороор дамжуулан бүртгэлд хамрагдах боломжтой болсон бөгөөд илгээсэн хүсэлтийн хариуг E-Mongolia системийн “Мэдэгдэл” цэсээс харах аж.

Цэргийн бүртгэлийн хүсэлт илгээхдээ дараах зүйлсийг анхаарна уу!

- 1.Цэргийн үүрэгтний үнэмлэх аваагүй 18 хүртэлх насны иргэд харьяа баг, хороон дээр өөрийн биеэр очиж бүртгэл үүсгэх шаардлагатай.
 - 2.Цэргийн үүрэгтний үнэмлэхгүй буюу хаяж гэсэн тохиолдолд харьяа аймаг, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабт өөрийн биеэр очин үнэмлэхээ авах шаардлагатай.
 - 3.Хаягийн шилжилт хийлгэсэн иргэд оршин суугаа аймаг, дүүргийн Цэргийн штабт хандан шилжилт хөдөлгөөнөө баталгаажуулж бүртгэлээ хийлгэх шаардлагатай.
- Өөрийн биеэр очихдоо дор дурдсан зүйлсийг заавал авч очно.
- 3 хувь цээж зураг
 - иргэний үнэмлэхийн хуулбар эсвэл лавлагаа
 - 2500 төгрөг

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-16	-27

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
36	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.467	3.474
EUR	3.680	3.710
CNY	500	503
RUB	46	47
JPY	26.20	26.50
KRW	2.75	2.77

ЗУРХАЙ



2022.01.04 / ЛХАГВА ГАРАГ / БИЛГИЙН ТООЛЛЫН 13

ӨВЛИЙН ДУНД ХАР ХУЛГАНА САР ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ХАР НОХОЙ ӨДӨ

Үс засуулбал:

ЖАРГАЛ ИРНЭ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.41-17.12

БАРИЛДЛАГА:

Идэр

Шүтэн барилдлага:

Төрөхүй

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн. гэрийн үйл, бие угаах, хувцас өмсөхөд сайн. Баруун нүд татвал зочин ирэх, зүүн нь татвал хувцас олдох, баруун чих цангинавал баярлах, зүүн нь бол муу. Нохой уливал амгалан сайн болох, тагнай загатнавал дээрэм ирэх, бие татвал аюул болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 666,039,018

Эдгэрсэн

Нийт: 638,097,122

Нас барсан

Нийт: 6,701,276

Цаг үе, үйл явдал

ЦЭРГИЙН ЖАГСААЛЫН ДҮРМИЙН ОНЦЛОГУУДААС ...



Шинэчлэгдсэн Цэргийн нийтлэг дүрмийн зарим өөрчлөлтийг та бүхэндээ танилцуулсаар байна. Тус дүрмийн Цэргийн жагсаалын дүрмийг есөн бүлэг, 43 зүйл, 383 хэсэг, 175 заалт, таван хавсралт, 56 зурагтай болгон шинэчлэн найруулжээ.

Хүндэт харуул нь төрийн ба цэргийн хүрээний гэж ангилагдана. Төрийн хүндэт харуул Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан "Төрийн ёслолын журам"-аар ажиллана.

Цэргийн ангийн "Байлдааны туг"-ийг залж гаргах, тугийг жагсаалд байрлуулах, буцааж оруулах ажиллагаа, илтгэлүүд, жагсаалын өмнө болон жагсаалд байгаа захирагч, цэргийн алба хаагчийн үүрэг, жагсаалын ажиллагаа хөдөлгөөн, командуудыг нарийвчлан тодорхойлжээ.

Нутгийн захиргааны хүсэлтийн дагуу Төрийн цэргийн байгууллагын даргын зөвшөөрлөөр Цэргийн хүрээний дарга тушаал гаргаж, цэргийн ангийг хүндэтгэлийн

ажиллагаанд оролцуулж болно.

Цэргийн ангид Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга хүрэлцэн ирэхэд "ХҮНДЭТ ХАРУУЛ" жагсааж, хүндэтгэн угтан авна.

Цэргийн ангид Хил хамгаалах, Дотоодын цэргийн болон Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Төрийн цэргийн байгууллагын дарга, Төрлийн цэргийн командлагч, төрлийн цэргийн командлалын цогцолбор болон төгсөлтийн шалгалтыг удирдахаар томилогдсон дарга хүрэлцэн ирэхэд АНГИ "жагсаж" угтан авахаар тусгажээ.

Хуучин дүрмээр хүндэт харуулын дарга хүндэт зочноо угтаж авахдаа цол, овог нэрээ бүтнээр нь хэлдэг байсан бол энэ удаа зөвхөн цол

болон нэрээ хэлнэ. Тухайлбал, "Монгол Улсын Батлан хамгаалахын сайд танаа, Таныг хүндэтгэн угтаж Чойбалсан цэргийн хүрээний хүндэт харуул жагссан, Хүндэт харуулын дарга, ахмад ..." (зөвхөн нэрээр)" гэж хэлнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийг угтан авах ёслолд 24 цэргийн алба хаагч бүхий гурван салааг, Монгол Улсын Их хурлын дарга, Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг угтан авах цэргийн ёслолд 24 цэргийн алба хаагч бүхий хоёр салааг, Байлдааны туг, цэргийн үлээвэр хөгжимтэй хамт тус тус томилохоор оруулжээ. Хүндэт харуулын дарга, салааны захирагч, туг хамгаалагч нар сэлэмтэй байна.

Та илүү дэлгэрэнгүй мэдээллийг хүсвэл "Цэргийн алба хаагчийн эрх зүй" апплейкшныг гар утсандаа татаж аваарай.



Онцолъё

МОНГОЛ УЛСЫН ДӨРӨВДӨХ РАЙНЖЕР...



Монгол Улсын 4 дэх рэйнжер бөгөөд анхны ахлагч RANGER, сургагч ахлагч Т.Мөнгөншагай дараах гэрэл зурагт харагдаж байна.

Монгол Улс одоогоор 6 рэйнжертэй бөгөөд анхны шанг дэслэгч генерал Д.Ганзориг тэртээ 2002 онд татаж, хурандаа С.Түвшинбаяр, хошууч генерал Л.Гансэлэм нар буухиалж, түүнээс хойш 20 орчим жилийн дараа сургагч ахлагч Т.Мөнгөншагай дахин "сэргээж", ахмад Г.Жавхлантөгс, сургагч ахлагч Б.Эрдэнэдаваа нарын 2 генерал, хоёр офицер, хоёр ахлагч зүүн мөрөндөө RANGER хэмээх тэмдэгтэй билээ

АНУ-ын Жоржиа муж дахь "Форт Беннинг" цэргийн бааз дахь Рейнжерийн сургууль нь 1950 онд байгуулагдсан. Сургуулийн өмнө 14 хоногийн бэлтгэл сургалт явагддаг. Үндсэн сургалт нь нийт 61 хоногийн хугацаанд үргэлжлэн жижиг бүлэг, уул болон ус, намгийн ажиллагаа гэсэн үндсэн 3 үе шаттайгаар явагддаг.

Энэ хугацаанд суралцагсад нь бие бялдрын болон сэтгэл зүйн өндөр бэлтгэл, асар их тэсвэртэйгээр тасаг, салааг удирдан зохион байгуулах чадварыг цаг агаар, цагийн байдлын ямар ч нөхцөлд олж авдагараа онцлогтой юм. Уг сургуулийг нийт суралцагчдын 45 хүрэхгүй хувь нь төгсдөг гэсэн статистик бий.



Сургалт

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №50

ШҮХЭРЧИН ДАЙЧДЫН ХӨДӨЛМӨРИЙН АВАРГУУДААР...



Зэвсэгт хүчний 084 дүгээр анги 2022 онд эрхэлсэн ажил, үйлсдээ өндөр амжилт гаргаж, хөдөлмөрч бүтээлч байдлаараа хамт олноо тэргүүлсэн хөдөлмөрийн аваргууд, тэргүүний алба хаагчдаа тодрууллаа.

Ангийн "Хөдөлмөрийн аварга хамт олон"-оор дэслэгч Б.Санжаадорж захирагчтай "Инженер сапёрын салаа"-ны хамт олон, "Хөдөлмөрийн аварга офицер"-оор Шүхэр десантын албаны тасгийн дарга, шүхэр десантын ахлах офицер, сургагч ахмад В.Баярсайхан, "Хөдөлмөрийн

аварга ахлагч"-аар Тусгай хүчний сургалтын нэгдсэн төвийн Буудлагын талбайн харуулчин ахлагч Д.Ган-Эрдэнэ, "Хөдөлмөрийн ажилтан"-аар Материал хангалтын албаны Хувцасны Нярав З.Цэцэгмаа, "Тэргүүний шүхэрчин"-ээр Шүхэр десантын нэгдүгээр ротын Гранатомётчин Ахлагч Б.Энхбат, "Тэргүүний тамирчин"-аар Байлдааны хангалтын салбарын холбоо салааны Р-142 радио станцын дарга Ахлах Ахлагч Х.Анхбаяр тус тус шалгарч шагналын ангийн захирагч хурандаа Д.Шинэбаяр гардуулж баяр хүргэлээ.

СА ҮСЭГ БҮХИЙ УНШИХ, БИЧИХ ДАДЛАГА

СА дэвсгэр бүхий, уншихад хялбар, нэг юм уу хоёрхон үеэс бүтсэн, бичлэг дуудлага нь өнөөгийнхтэй их төлөв таардаг хялбар жишээ үгсийг унших, бичих дасгал дадлага хийцгээе. Зөв уншаад, цэвэр сайхан бичиж, кириллээр хөрвүүлээрэй.

Дармал, бичмэл тигээр:

